



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/201

Булган сум

“Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл”-ийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2, 28.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.3.1, 30.3.2 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2026 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж, нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүрэг бүхий “Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

М.Батчимэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Э.Эрдэнэжаргал (Аймгийн Засаг даргын тамгын
газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Мэндсайхан (Аймгийн Ажил олгогч эздийн
холбооны тэргүүн)

Д.Баярмагнай (Аймгийн Ажил олгогч эздийн
холбооны тэргүүлэгч)

Ч.Отгонжаргал (Аймгийн Ажил олгогч эздийн
холбооны тэргүүлэгч)

Д.Баярсайхан (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн
холбооны дарга)

Т.Дорж (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны
тэргүүлэгч)

Ч.Оюун (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны
тэргүүлэгч)

Нарийн бичгийн дарга: Г.Нямдорж (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга)

6326010269

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжигдэх төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тайлан мэдээг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллага, албан тушаалтныг эргэн мэдээллээр хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлийн дарга (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны А/224 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ЛҮРЭВ-ОЧИР